

2012 ОНЫ 8 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2012 оны 9 дүгээр сарын 18

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 08 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	/тоогоор/			
		2012-07 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2012-08 сар
1	Даатгалын компани	18			18
2	Даатгалын компанийн салбар	191	4 ¹		195
3	Даатгалын төлөөлөгч	2337	39 ²		2376
4	Даатгалын зуучлагч	13	1 ³		14
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			9
6	Актуарч	15			15
7	Бусад	15			15

Тайлант үед даатгалын компанийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹ Хорооны 2012 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 165 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Сонгинохайрхан болон Багануур дүүргийн нутаг дэвсгэрт, 2012 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 166 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт, 2012 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 175 дугаар тушаалаар “Номин даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Багануур дүүргийн нутаг дэвсгэрт тус тус даатгалын салбар нээн ажиллуулах зөвшөөрөл олгосон байна.

² Хорооны 2012 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 169 дүгээр тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн 39 иргэнд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон байна.

³ Хорооны 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор “Хаан банк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2012 оны 08 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг тайлант үеийн өссөн дүнтэй харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :


/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2012.08.31 /сарын дүн/	2012.08.31 /өссөн /
Даатгалын нийт хураамж	6,157,878.60	51,470,154.80
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	644,230.50	9,507,175.90
Олгосон нийт нөхөн төлбөр	1,232,877.80	8,763,761.60
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	350,211.60	1,348,922.90
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	770.00	3,043.00
Давхар даатгалд төлсөн хураамж	1,375,101.20	11,273,385.80
Байгуулсан даатгалын гэрээний тоо	21,606.00	283,899.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	13,503.00	200,100.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	16,906.00	232,758.00
Хамгийн өндөр дүнтэй даатгалын гэрээ		.00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	4,401,558,740.00	4,401,558,740.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	.00	.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	404,256.20	404,256.20

2012 оны 08 дугаар сарын байдлаар даатгалын хураамжийн орлого 2011 оны мөн үеийнхээс 4635.5 сая төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого өмнөх сараас 1.07 дахин өссөн байна. Оны эхний 08 дугаар сарын байдлаар нийт 9507.2 сая төгрөг болсон байна.




2012 оны 08 дугаар сарын байдлаар даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 404.2 сая төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн. Жолоочийн албан журмын даатгалын нөхөн төлбөр өмнөх сараас 1.6 дахин өссөн байна.




Ердийн даатгалын компаниудын 2012 оны 08 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Мандал женерал даатгал” ХХК-ийн байгуулсан 4401.5 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын гэрээ байна. “Монгол даатгал” ХХК нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болох 30.3 сая төгрөгийг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	8-р сар	/Төгрөгөөр/ Нийт дүн
Даатгалын нийт хураамж	11,391,760.50	406,587,438
Олгосон нийт нөхөн төлбөр	10,171,545.00	76,475,443
Давхар даатгалд төлсөн хураамж	614,168.50	26,341,666
Байгуулсан даатгалын гэрээний тоо	12.00	124
Хувь хүний хугацаат даатгалд	4.00	31
Байгууллагын хугацаат даатгалд	0.00	16
Өндөр хамгаалалттай ЭМД-д	0.00	0
Эмнэлгийн мөнгөний даатгалд	3.00	25
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	2.00	28
Тэтгэврийн даатгалд	1.00	12
Орон сууцны даатгалд	0.00	4
Хуримтлалын даатгалд	2.00	8
Зээлдэгчийн амь насны даатгалд	0.00	0
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15,000,000.00	623,695,000
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	5,250,000.00	29,400,000



Урт хугацааны даатгагчийн даатгалын хураамжийн орлого 2012 оны 08 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 2.5 дахин буурсан байна.



2012 оны 08 дугаар сарын байдлаар урт хугацааны даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 1.8 дахин буурсан байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	8-р сар	Нийт дүн
Даатгуулагчаас шууд орж ирсэн дүн даатгалын хураамж	46,617,840.93	464,144,161.22
Даатгалын зуучлагчийн орлого	28,935,628.48	261,000,998.43
Зуучилсан даатгалын гэрээний тоо	321.00	4,088.00

2012 оны 8 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 46.6 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон ба өмнөх оны мөн үеийнхээс 1.3 сая төгрөгөөр буурсан байна.

Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр дүнтэй буюу 6683.3 сая төгрөгийн үнэлгээтэй 23.1 сая төгрөгийн хураамж бүхий даатгалын гэрээг “Эм жи ай би” ХХК зуучлан борлуулсан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмэнт” ХХК, “Гэрэлт буян ундрах” ХХК, “Си эн эн икс” ХХК-иуд 08 дугаар сарын мэдээ ирүүлээгүй болно.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

		/төгрөгөөр/
Үзүүлэлт	8-р сар	Нийт дүн
Даатгалын хохирол үнэлсэний орлого	16,276,400.00	81,592,691
Үнэлсэн даатгалын хохиролын тоо	887.00	4,382
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	56,879,352.00	56,879,352

2012 оны 08 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 16.3 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оны мөн үеэс 11.0 сая төгрөгөөр буюу 4.4 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК, “Мега марз” ХХК-иуд үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 235 дугаар тогтоолоор “Монре даатгал” ХХК, 237 дугаар тогтоолоор “Гэр даатгал” ХХК-иудад тус тус дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.

Хорооны 2012 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 268 дугаар тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК-д барилга угсралтын даатгалын хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгосон бөгөөд 269 дүгээр тогтоолоор тус компанийн гүйцэтгэх захирлаар Чимид овогтой Батцогтыг томилохыг зөвшөөрсөн шийдвэрийг гаргасан байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

2012.09.18